

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 01 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, А.Бакей, С.Батболд, Д.Батцогт, Ц.Даваасүрэн, С.Дэмбэрэл, С.Одонтуяа, Д.Оюунхорол, Г.Уянга нарын 2013 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гаргасан болно.

Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд, Н.Энхболд, Р.Гончигдорж нар Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлогын баримт бичиг, хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаарх Засгийн газар болон холбогдох байгууллагуудын мэдээллийг нэгтгэн дүгнэлт хийсний үндсэн дээр хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулж, цаашид хөгжлийн бодлого, түүний төлөвлөлт, хэрэгжилтийн механизмыг боловсронгуй болгох асуудлыг цогцоор нь авч үзэж шийдвэрлэх нь зүйтэй гэсэн санал гаргасныг Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжсэн болно.


Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр энэ чиглэлд олон улсын парламентын сайн туршлагыг нэвтрүүлэх, ирээдүйн хөгжлийн цогц бодлогыг боловсруулан батлуулах, боловсронгуй болгох, Засгийн газрын үйл ажиллагаа, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон асуудлыг хариуцсан УИХ-ын дэд хороог цаашид байгуулан ажиллуулах, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд судалгаа шинжилгээний үр дүн, олон нийтийн саналыг авч тусгах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баярсайхан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилт удаашралтай байгааг тэмдэглээд үйлдвэрлэл, хүн амын нутагшил, суурьшлын схем зэрэг Засгийн газраас одоо боловсруулж байгаа хөтөлбөр, төслүүдийг хэлэлцэж буй асуудалтай уялдуулах нь зүйтэй гэсэн саналыг тус тус гаргав.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт тогтоолын төсөл санаачлагчийн хувьд бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд нухацтай дүгнэлт хийсний үндсэн дээр хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох асуудлаар Улсын Их Хурал түр хороо байгуулан ажиллуулж болох юм гэсэн саналыг хэллээ. Мөн Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд дээрх асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллах нь зүйтэй гэсэн санал гаргав.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн тухай Аюулгүй байдал, гадаад бодлогын

байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж байна.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ОЮУНБААТАР